НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 15 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1 дүгээр шатны төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дах хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйлийн 49.3 дах хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дах хэсэг, дүүргийн ИТХ-ын 2020 оны А/23 тоот тогтоолын 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 18 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны 2020-2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд, 2022 оны жилийн эцсийн байдлаар 98.7 хувийн хэрэгжилттэй, “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Дүүргийн Жендэрийн хорооны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, ажлыг зохион байгуулахыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо (Б.Болормаа)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА Ф.МӨНХГЭРЭЛ